

**ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
СООДОЙХҮҮ ОВОГТОЙ ЭРДЭМСУВДЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | Биелэлтийн хувь |
|--|---|---|---|---|---|-------------------------|-----------------|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн дууссан хугацаа | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилго 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах (Хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго) | | | | | | | |
| Зорилго 3. Нийслэлийн төсөвт байгууллагуудын удирдлагатай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний хэрэгжилтийг дүгнэх (НИТХТ-ийн 2014 оны 55 дугаар тогтоол) | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ: 2.3.1 Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2023 оны биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах | -Гэрээ дүгнүүлсэн хуулийн этгээдийн тоо -Үнэлэгдсэн байдал | Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой байгууллагуудаас түүвэрчилсэн байдлаар 10 байгууллагын гэрээг дүгнэсэн. (Бүрэн хангалттай - 7, Хангалттай үнэлгээ 2, Дүгнэгдээгүй 1) | -Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой байгууллагуудаас түүвэрчилсэн байдлаар 20 байгууллагын гэрээг дүгнэнэ. -Төлөвлөсөн хуваарийн дагуу гэрээ дүгнэн дүнгийн нэгтгэл, хуудсыг боловсруулсан байна. -Гэрээний дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ. | Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн төсөвт 21 байгууллагын удирдлагатай байгуулсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэж дууслаа. Нийт 22 байгууллага дүгнэхээс 21 байгууллага дүгнэсэн. Үүнд: • Хэрэгжүүлэгч агентлаг-4 • Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар-1 • Сургууль-7 • Цэцэрлэг-4 • Өрхийн эрүүл мэндийн төв-4 "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн дүнгээр 12 байгууллага "Бүрэн | I-IV | 100% |

| | | | | | | | | |
|--|--|---|---|--|--|--|------|--|
| | | | | | | хангалтай", байгууллага "Хангалттай" 7, 2 байгууллага "Ажил шаардлагатай" үнэлгээ авсан. | | |
| 2. | Арга хэмжээ: 2.3.2 НИТХТ-ын 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах | -Хуулийн этгээдийн тоо -Гэрээний тоо | -Нийслэл, дүүргийн нийт 4 газрын удирдлагатай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулсан. | Нийслэл, дүүргийн нийт 94 газрын удирдлагатай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулна. | Тайлангийн хугацаанд нийт Сүхбаатар дүүргийн 95 төсөвт байгууллагын удирдлагуудтай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулсан. | I-II | 100% | |
| Зорилт 5. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн хөдөлгөөн түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах, хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавих зорилт (НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоол) | | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ: 2.5.1 Нийслэлийн Засаг даргын хөрөнгө оруулалттай холбоотой 2024 оны хүлээн авсан захирамжуудыг үндэслэн төсөл арга хэмжээг хөрөнгийн эх үүсвэрээр ангилан, судалгааг гаргах | -Төсөл, арга хэмжээний тоо, мөнгөн дүн | Нийт 5 006,8 сая төгрөгийн 28 ажлын дүнд бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон 28 албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн. | Шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэсэн тухай мэдээллийг судалгаанд нэгтгэсэн байна. | Нийт 3,332.5 сая төгрөгийн 10 ажлын дүнд бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон 10 албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн. | I-IV | 100% | |
| 4. | Арга хэмжээ: 2.5.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд баригдаж ашиглалтад орсон барилга байгууламж, бий болсон тээврийн хэрэгсэл, тохижилтын ажлуудыг нийслэлийн өмчид буюу нийслэлийн өмчит төсөвт байгууллагын бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах. | -Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая.төг | -Өнгөрсөн онд нийт нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрөөр шинээр бий болсон нийт 14 810,8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэлээ. | -Шинээр бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэнэ. | Тайлант хугацаанд нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрөөр шинээр бий болсон нийт 10,268.3 сая төгрөгийн барилга байгууламж бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: -Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан НЭБ-ын 159 дүгээр сургуулийн 960 хүүхдийн барилгыг нийслэлийн өмчид бүртгэх асуудлыг хэлэлцүүлэн НИТХ- | | 100% | |

| | | |
|--|--|---|
| | | <p>ын 2024 оны 32 дугаар тогтоолоор шийдвэрлэж, НЗД-ын 2024 оны А/417 дугаар захирамжаар НЭБ-ын 159 дүгээр сургуульд балансдаа бүртгэн авч ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг даалгасан.</p> <p>-Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан цэцэрлэгийн барилгыг нийслэлийн өмчид бүртгэх асуудлыг хэлэлцүүлэн НИТХ-ын 2024 оны 111 дүгээр тогтоолоор шийдвэрлэж, НЗД-ын 2024 оны А/1292 дугаар захирамжаар СБД-ийн 75 дугаар цэцэрлэгт балансдаа бүртгэн авч ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг даалгасан.</p> <p><u>НЗД-ын захирамжаар бүртгэсэн тээврийн хэрэгсэл</u> - 507.7 сая төгрөг</p> <p>НЗД-ын 2024 оны А/147 дугаар захирамжаар СБД-ийн Онцгой байдлын хэлтэст Саплей чейн ххк-ийн хандиваар 30.0 сая төгрөгийн үнэтэй 1 тээврийн хэрэгслийг бүртгүүлсэн.</p> <p>НЗД-ын 2024 оны А/1034 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бэлтгэгдсэн 448.0 сая төгрөгийн үнэтэй түргэн тусламжийн 4 тээврийн хэрэгслийг Нийслэлийн Хүрээ амаржих газар, Нийслэлийн</p> |
|--|--|---|

| | | | | | | | |
|---|---|--|--|--|---|-------------|--|
| | | | | | <p>Түргэн тусламжийн төв болон Нийслэлийн Өргөө амаржих газарт бүртгүүлсэн.</p> <p><u>Тохижилт, засварыг ажил нийт 3,332.5 сая төгрөг</u></p> <p>Захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрөөр бий болсон нийтийн эзэмшлийн тохижилт, засварыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийн дагуу нийт 3,332.5 сая төгрөгийн эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон 10 албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн</p> | | |
| <p>5. Арга хэмжээ: 2.5.3 Хандив бэлэглэл, буцалтгүй тусламж, зээл, төсөл хөтөлбөрөөр бий болсон эд хөрөнгийг холбогдох журмын дагуу нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах</p> | <p>-Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая.төг -УХХХК-ын хурлын шийдвэр</p> | <p>-Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хандив тусламж, төсөл хөтөлбөрийн хүрээнд шинээр бий болсон 83.9 сая төгрөгийн хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгах асуудлыг УХХХК-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.</p> | <p>-Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу бүртгэлд тусгах арга хэмжээг авч ажиллана. -УХХХК-ын хурлаар хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар баталгаажуулсан байна.</p> | <p><u>УХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө – 91 сая төгрөг</u></p> <p>Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн давхардсан тоогоор 7 байгууллагуудын хүсэлтийг хэлэлцүүлж 91 сая төгрөгийн эд хөрөнгийг бүртгэх ажлыг УХХХК-ийн 1-12-р хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, газрын даргын тушаалыг гаргуулан, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.</p> | <p>I-IV</p> | <p>100%</p> | |

| | | | | | | |
|----|--|---|---|---|---|---------------------------|
| 6. | <p>Арга хэмжээ: 2.5.4 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн баланссад бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг акталж, данснаас хасах</p> | <p>-Акталсан барилгын тоо -Мөнгөн дүн сая.төг</p> | <p>-</p> | <p>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ирүүлсэн хүсэлтийн дагуу тогтоол, захирамжийн төсөл боловсруулан, батлуулж холбогдох арга хэмжээг авч ажиллана.</p> | <p>Тайлант хугацаанд хуулийн этгээдийн баланссад бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй 289.0 сая төгрөгийн барилга байгууламжийг акталж, данснаас хассан ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: НИТХ-ын 2024.09.16-ны өдрийн 116 дугаар тогтоол, НЗД-ын 2024.11.06-ны өдрийн А/1275 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэгийн баланссад 271,708,192.09 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга, Нийслэлийн Хүрээ амаржих газрын баланссад 17,335,595.30 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг буулгах шийдвэр гарсан.</p> | <p>I-IV 100%</p> |
| 7. | <p>Арга хэмжээ: 2.5.6 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн баланссад бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгийг акталж, данснаас хасах</p> | <p>-Хөрөнгийн мөнгөн дүн сая.төг -ҮХХХК-ын хурлын шийдвэр</p> | <p>Нийт 2 322,5 сая төгрөгийн үндсэн данснаас хөрөнгийг данснаас хасч, актлах асуудлыг шийдвэрлүүлсэн..</p> | <p>СБД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн асуудлыг судлан, боловсруулж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ.</p> | <p>Тайлангийн хугацаанд ашиглалтын шаардлага хангахгүй болсон, элэгдлээрээ өртөө нөхсөн хөдлөх хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасуулах СБД-ийн 34 /давхардсан тоогоор/ байгууллагын хүсэлтийг судлан асуудлыг боловсруулан ҮХХХК-ын 1-12 дугаар хурлаар хэлэлцүүлж, нийт 2,036.2 сая төгрөгийн эд хөрөнгийг акталж Данс бүртгэлээс хасах Газрын даргын тушаалыг гаргуулж хүргүүлсэн.Мөн данснаас хасагдсан хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 8.3 сая төгрөгөөр худалдан</p> | <p>I-IV 100%</p> |

| | | | | | | |
|-----|---|--|--|---|--|----------------------|
| | | | | | <p>борлуулж, орлогын 30 хувь болох 2.5 сая төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дансанд төвлөрүүлэх шийдвэрийг гаргуулсан байна.</p> | |
| 8. | <p>Арга хэмжээ: 2.5.7 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу барилга байгууламж, тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх</p> | <p>-Балансаас балансад шилжсэн хөрөнгийн тоо -Мөнгөн дүн сая.төг</p> | | <p>СБД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн асуудлыг судлан, боловсруулж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ.</p> | <p>Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн балансд 70.4 сая төгрөгийн бүртгэлтэй тээврийн хэрэгслийг Нийслэлийн ЗООНОЗ-ын өвчин судлалын төвийн балансд НЗД-ын 2024 оны А/681 захирамжаар шилжүүлсэн.</p> | <p>I-IV 100%</p> |
| 9. | <p>Арга хэмжээ: 2.5.8 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу эд хөрөнгийг данснаас дансанд шилжүүлж, залруулга хийх асуудлыг шийдвэрлэх</p> | <p>-Хөрөнгийн мөнгөн дүн сая.төг -ҮХХХК-ын хурлын шийдвэр</p> | <p>Нийт 2 байгууллагын 14,8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас дансанд шилжүүлсэн.</p> | <p>-ҮХХХК-ын хурлаар хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар баталгаажуулсан байна.</p> | <p>ҮХХХК-ын хурлаар байгууллагын 14.2 сая төгрөгийн хөдлөх хөрөнгийг бусад хангамжийн материал данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> | <p>I-IV 100%</p> |
| 10. | <p>Арга хэмжээ: 2.5.9 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу эд хөрөнгийг дахин үнэлэх</p> | <p>-Дахин үнэлсэн хөрөнгийн дүн сая.төг</p> | <p>Нийт 2 байгууллагын цаашид ашиглах жилийг тогтоож, дахин үнэлсэн хөрөнгийг "ҮХХХК"-ын хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл олгосон. Үүнд 1 144,8 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй хөрөнгийг 573,0 сая төгрөгөөр дахин үнэлсэн болно.</p> | <p>-СБД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн асуудлыг судлан, боловсруулж, ҮХХХК-ын хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлнэ.</p> | <p>Элэгдлээрээ ертөө нехсэн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг 3 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн байгууллагын ӨХБЗХ-ын шийдвэрээр цаашид ашиглах жилийг тогтоож, дахин үнэлсэн хөрөнгийг ҮХХХК-ын хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл олгосон. Үүнд: 114,8 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй хөрөнгийг 54,8 сая төгрөгөөр дахин үнэлсэн болно.</p> | <p>I-IV 100%</p> |
| 11. | <p>Арга хэмжээ: 2.5.13 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн</p> | <p>-Мэдээллийн сан баяжигдах</p> | <p>Нийт 95 хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн</p> | <p>ТӨБЗГ-аас ирүүлсэн маягт, аргачлалын дагуу 2023 оны</p> | <p>ТӨБЗГ-аас нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн</p> | <p>I-IV 100%</p> |

| | | | | | | | |
|-----|---|--|--|---|--|-------------|-------------|
| 8. | <p>Арга хэмжээ: 2.5.7 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу барилга байгууламж, тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх</p> | <p>-Балансаас балансад шилжсэн хөрөнгийн тоо -Мөнгөн дүн сая.төг</p> | | <p>СБД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн асуудлыг судлан, боловсруулж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ.</p> | <p>Нийслэлийн түргэн тусламжийн төвийн баланс 70.4 сая төгрөгийн бүртгэлтэй тээврийн хэрэгслийг Нийслэлийн ЗООНОЗ-ын өвчин судлалын төвийн баланс НЗД-ын 2024 оны А/681 захирамжаар шилжүүлсэн.</p> | <p>I-IV</p> | <p>100%</p> |
| 9. | <p>Арга хэмжээ: 2.5.8 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу эд хөрөнгийг данснаас дансанд шилжүүлж, залруулга хийх асуудлыг шийдвэрлэх</p> | <p>-Хөрөнгийн мөнгөн дүн сая.төг -УХХХК-ын хурлын шийдвэр</p> | <p>Нийт 2 байгууллагын 14.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас дансанд шилжүүлсэн.</p> | <p>-УХХХК-ын хурлаар хэлэлцүүлэн, газрын даргын тушаалаар баталгаажуулсан байна.</p> | <p>УХХХК-ын хурлаар байгууллагын 14.2 сая төгрөгийн хөдлөх хөрөнгийг бусад хангамжийн материал данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> | <p>I-IV</p> | <p>100%</p> |
| 10. | <p>Арга хэмжээ: 2.5.9 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу эд хөрөнгийг дахин үнэлэх</p> | <p>-Дахин үнэлсэн хөрөнгийн дүн сая.төг</p> | <p>Нийт 2 байгууллагын цаашид ашиглах жилийг тогтоож, дахин үнэлсэн хөрөнгийг "УХХХК"-ын хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл олгосон. Үүнд 1 144,8 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй хөрөнгийг 573,0 сая төгрөгөөр дахин үнэлсэн болно.</p> | <p>-СБД-ийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн асуудлыг судлан, боловсруулж, УХХХК-ын хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлнэ.</p> | <p>Элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг 3 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн байгууллагын ӨХБЗХ-ын шийдвэрээр цаашид ашиглах жилийг тогтоож, дахин үнэлсэн хөрөнгийг УХХХК-ын хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл олгосон. Үүнд 114,8 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй хөрөнгийг 54,8 сая төгрөгөөр дахин үнэлсэн болно.</p> | <p>I-IV</p> | <p>100%</p> |
| 11. | <p>Арга хэмжээ: 2.5.13 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн</p> | <p>-Мэдээллийн сан баяжигдах</p> | <p>Нийт 95 хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн</p> | <p>ТӨБЗГ-аас ирүүлсэн маягт, аргачлалын дагуу 2023 оны</p> | <p>ТӨБЗГ-аас нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн</p> | <p>I-IV</p> | <p>100%</p> |

| | | | | |
|--|--|--|--|---|
| 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, мэдээллийн санг бүрдүүлэх (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль) | тайланг хүлээн авч, үндсэн хөрөнгийн тодруулгыг шалган тулгалт хийв. | санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэн хүргүүлсэн байна. | тайланг программээр хүлээн авах болсонтой холбогдуулан сургалтыг 2024.02.23-ны өдөр хийсэн сургалтад СБД-ийн 96 төсөвт байгууллагад зар тараасан болно. Сүхбаатар дүүргийн нийт 96 нийслэлийн өмчит төсөвт байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлангийн нэгтгэл, тодруулгыг шалган тулгалт хийж, "Төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны цахим систем" – зэр нэгтгэв. Мөн хөрөнгийн бүртгэл мэдээллийн болон захиргааны статистикийн ний 17 маяггаар жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээг хүлээн авав. | |
| Зорилго 3. Байгууллагын захиргаа, хүний нөөц, төсөв санхүүтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах (Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх) | | | | |
| Зорилт 1. Байгууллагын захиргаа, хүний нөөцийн эрхэлсэн асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилт | | | | |
| 12. Арга хэмжээ: 3.1.10 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих | -Тарьсан модны тоо -Албан хаагчдын оролцоог хангуулах | 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрүүдэд Налайх дүүргийн "Шинэ-Налайх" цэцэрлэгт хүрээлэнд 5 шинэс модны байгууллагын албан хаагчдын хамт суулгасан. | Мод тарих арга хэмжээ 1-2 удаа оролцоно. | "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Налайх дүүргийн "Шинэ-Налайх" цэцэрлэгт хүрээлэнд мод тарих нээлтийн арга хэмжээнд оролцон өөрсдийн зардлаар шинэс модны суулгац авч, хуваарилсан талбайд суулгасан. |

| | | | | | | | |
|-----|---|-----------------------------|---|---|--|------|------|
| 13. | Арга хэмжээ: 3.1.11 2024 оны "Тохжилт бүтээн байгуулалт"-ын жил төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу байгууллагын хэмжээнд арга хэмжээ шинээр санаачлан ажиллахад оролцох | - | -Төлөвлөгөөний хэрэгжилтийн ханган ажилласан байх | Нийслэлийн батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээ төлөвлөн ажилласан байна. | -2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан хуваарийн дагуу Баянбүрдийн тойргоос урагшаа Тусгаар тогтнолын талбайн урд үзүүр хүртэлх талбай болон Байгууллагын оффисын дотор ажлын байр, өрөө тасалгаанд тус тус их цэвэрлэгээ хийсэн. | I-IV | 100% |
| 14. | Дэд арга хэмжээ Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх | -Цаг хугацаандаа шийдвэрлэх | 100% | | Тайлант хугацаанд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 256 албан бичиг хүлээн авснаас 80 албан бичигт хуулийн хугацаанд нь хариуг өгч 6 албан бичиг судлагдаж байна. | I-IV | 90% |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|-----|--|--|--------------|--|--|---------------|----------------|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 15. | Дэд арга хэмжээ Албан хаагчийн албан үүргээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцох | Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байх | 100% | Танхимаар болон цахимаар суралцана. Сургалтад идэвхитэй оролцож мэдлэг ур чадвараа дээшлүүлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. | НЭДТГ-аас болон байгууллагаас зохион байгуулсан дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд: -Худалдан авгах ажиллагааны сертификатыг олгох сургалт цахим сургалт, түүх, Нийслэлийн нутгийн захиргааны | I-IV | 100% |
| | | | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | |
|--|--|--|--|---|--|
| | | | | байгууллагуудын бүтэц, чиг үүрэг; -Өөрчлөлтийн менежмент, -MS Excel /дунд шат, ахисан шат/; -Жендерийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо; Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх; -ТӨБЭГ-ын төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын нэгдсэн сургалт зөвөлгөө; -2024 оны 7:4:10 цахим сургалтуудад хамрагдсан байна. -ТӨБЭГ-ын 2024.11.28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн Шинэчлэл ба зах зээл хэлэлцүүлэг уулзалт -2024 оны 12 сард компанийн засаглалын хөгжлийн төвийн сургалт. | |
|--|--|--|--|---|--|

Тайлан гаргасан:

Ө.У.З.Х - ш.м.н. о.х.м.х. м.р.г.н.ш.м.х.т.ө.м

(Албан тушаал)

Эрхэнцүр

(Нэр, гарын үсэг)

2024.12.05

(Огноо)

**ӨМЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ЭРДЭМСУВДЫН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2024.12.05

Улаанбаатар хот

***НЭГ. НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭД ХӨРӨНГИЙН
ХӨДӨЛГӨӨН, ХОЛБОГДОХ БУСАД ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ АЖЛЫН
ХҮРЭЭНД:***

1.Шинээр бий болсон эд хөрөнгийг бүртгэх ажлын талаар:

Тайлант хугацаанд нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрөөр шинээр бий болсон нийт **15,525.7 сая** төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгах ажлыг хийж гүйцэтгэлээ. Задлаж үзүүлбэл:

Нэг.НИТХ-ын тогтоолоор бүртгэсэн барилга байгууламж – 10,268.3 сая төгрөг

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Сүхбаатар дүүргийн 159 дүгээр 960 хүүхдийн сургуулийн барилгыг нийслэлийн өмчид бүртгэх асуудлыг хэлэлцүүлэн 32 дугаар тогтоолоор шийдвэрлэж, НЗД-ын 2024 оны А/417 дугаар захирамжаар СБД-ийн 159 дүгээр сургууль балансаа бүртгэн авч ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг даалгасан.



- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан цэцэрлэгийн зориулалттай орон сууцны нэг давхрын барилгыг нийслэлийн өмчид бүртгэх асуудлыг хэлэлцүүлэн НИТХ-ын 2024 оны 111 дүгээр тогтоолоор шийдвэрлэж, НЗД-ын 2024 оны

A/1292 дугаар захирамжаар СБД-ийн 75 дугаар цэцэрлэгт балансдаа бүртгэн авч ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг даалгасан.



Хоёр. НЗД-ын захирамжаар бүртгэсэн тээврийн хэрэгсэл – 507.7 сая төгрөг

- НЗД-ын 2024 оны А/147 дугаар захирамжаар СБД-ийн Онцгой байдлын хэлтэст Саплей чейн ххк-ийн хандиваар 30.0 сая төгрөгийн үнэтэй 1 тээврийн хэрэгслийг бүртгүүлсэн.

- НЗД-ын 2024 оны А/1034 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр бэлтгэгдсэн 448.0 сая төгрөгийн үнэтэй түргэн тусламжийн 4 тээврийн хэрэгслийг Нийслэлийн Хүрээ амаржих газар, Нийслэлийн Түргэн тусламжийн төв болон Нийслэлийн Өргөө амаржих газарт бүртгүүлсэн.

Гурав. ҮХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн 7 байгууллага хүсэлтээ ирүүлсэн. Нийт ҮХХХК-ын 1-11 дүгээр хурлаар 91.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

Дөрөв. Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал – 3,332.5 сая төгрөг

Захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө,

хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрөөр бий болсон нийтийн эзэмшлийн тохижилт, засварыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийн дагуу нийт 3,332.5 сая төгрөгийн эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон **10** албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд:

НХОГ-ын 2024 оны 01/1744, 2/760, 2/446 тоотуудын дагуу:

1. СБД-ийн 1-10 хороодын иргэний танхимын тохижилт тавилга;
2. НЕБ-ын 159 дүгээр сургуулийн хөлбөмбөгийн талбай шинээр байгуулах, тохижилтын ажил;
3. СБД-ийн 18, 19, 20 дугаар хороодод олон улсын стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажил;
4. СБД-ийн 248 дугаар цэцэрлэгийн гадна дулаан хангамж ариутгах татуургын ажил;
5. НЕБ-ын 2 дугаар сургуулийн сантехникийн засварын ажил;
6. СБД-ийн 16 дугаар хороонд Автозам тохижилтын ажлууд
7. СБД-ийн 2 хороо, НЕБ-ын 2 дугаар сургуулийн барилгын засвар
8. СБД-ийн 11-р хороо НЕБ-ын 131 дүгээр сургуулийн барилгын засвар
9. СБД-ийн 15 хороо, Эрдмийн хөтөч сургууль засварын ажил
10. СБД-ийн 15 хороо, Эрдмийн хөтөч сургууль засварын ажил

НӨХГ-ын 2024 оны 3/307, 3/305, 3/353, 2/281, 3/401, 3/449, 3/913, 3/914, 3/915, 3/945 дугаар албан бичгийг хүргүүлж, дансандаа бүртгэж, ашиглалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг холбогдох байгууллагуудад даалгасан.

Тав. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон эргэлтийн бус хөрөнгийг байгууллагын даргын тушаалаар бүртгэж, тушаалын хуулбараа ирүүлсэн байдал – 1,326.2 сая төгрөг

Нийт хавсралтад заасан давхардсан тоогоор 60 байгууллага нь улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр бий болсон 1,326.2 сая төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгө /тоног төхөөрөмж, тавилга эд хогшил/-ийг байгууллагын даргын тушаалаар бүртгэж, тушаалын хуулбараа ирүүлсэн байна.

2. Хөрөнгө данснаас хасч, актлах асуудлын талаар:

Тайлант хугацаанд ашиглалтын шаардлага хангахгүй болсон, элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг актлаж, данс бүртгэлээс хасуулах хүсэлтийг судлан үзэж нийт **2,325.2 сая** төгрөгийн хөрөнгийг актлаж данс бүртгэлээс хасуулсан. Задлаж үзүүлбэл:

Нэг .НИТХ-ын тогтоолоор хассан барилга байгууламж – 289.0 сая төгрөг

НИТХ-ын 2024.09.16-ны өдрийн 116 дугаар тогтоол, НЗД-ын 2024.11.06-ны өдрийн А/1275 дугаар захирамжаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Нийслэлийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2013 оны 02-07-78/1975, 2022 оны 02-07-091/852 дугаар дүгнэлтийг үндэслэн буулгаж шинэ барилга баригдах

болсонтой холбогдуулан Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэгийн балансад 271,708,192.09 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг буулгах шийдвэр гарсан.

НИТХ-ын 2024.09.16-ны өдрийн 116 дугаар тогтоол, НЗД-ын 2024.11.06-ны өдрийн А/1275 дугаар захирамжаар хуучин харуулын байрыг шинэ эмнэлгийн барилгад зориулан хүчилтөрөгчийн үйлдвэр барих, гадна талбайн тохижилтын ажил хийгдэхээр болсон тул Нийслэлийн Хүрээ амаржих газрын балансад 17,335,595.30 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг буулгах шийдвэр гарсан.

Хоёр. ҮХХХК-ын хуралд оруулан шийдвэрлүүлсэн асуудлууд:

Тайлангийн хугацаанд ашиглалтын шаардлага хангахгүй болсон, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөдлөх хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасуулах Сүхбаатар дүүргийн 34 /давхардсан тоогоор/ байгууллагын хүсэлтийг судлан асуудлыг боловсруулан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлж, нийт 2,036.2 сая төгрөгийн эд хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах Газрын даргын тушаалыг гаргуулж хүргүүлсэн. Сүхбаатар дүүргийн нийслэлийн өмчит 34 байгууллагаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг Хөрөнгө хариуцсан ахлах менежер Нанжид болон Ц.Дөлгөөнзаяатай хамт газар дээр нь очиж үзэн, ҮХХХК-ийн 1-11 дүгээр хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Мөн данснаас хасагдсан хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 8.3 сая төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 2.5 сая төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дансанд төвлөрүүлэх шийдвэрийг гаргуулсан байна.

3.Хөрөнгө худалдан авах талаар:

Хариуцсан байгууллагуудаас хөрөнгө худалдан авах санал ирээгүй болно.

4.Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх талаар:

Нэг.Нийслэлийн Засаг даргын захирамжаар:

НЗД-ын 2024 оны А/681 дүгээр захирамжаар Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн балансад 70,416,000.00 төгрөгийн бүртгэлийн үнэтэй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвд балансаас балансад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн.

Хоёр.ҮХХХК-ын хуралд оруулан шийдвэрлүүлсэн балансаас балансад шилжүүлсэн асуудлууд:

Дээрх ажлын хүрээнд балансаас балансад шилжүүлэх тухай хүсэлтийг 5 байгууллагаас ирүүлсэн байна. Нийт 122 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн байна.

5.ӨМЧ ЭЗЭМШЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ АЖЛЫН ТАЛААР:

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/90 дүгээр тушаалаар "Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2023 оны биелэлтийг дүгнэх Ажлын хэсэг байгуулагдан Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн С.Эрдэмсүвд, Өмчийн менежментийн хэлтсийн мэргэжилтэн Б.Батаа, Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн Ш.Дарьсүрэн нарын бүрэлдэхүүнтэй томилогдон 2023 оны биелэлтийг дүгнэлээ.

Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн төсөвт 21 байгууллагын удирдлагатай байгуулсан "Нийслэлийн Өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэж дууслаа.

Нийт 22 байгууллага дүгнэхээс 21 байгууллага дүгнэсэн. Үүнд:

- Хэрэгжүүлэгч агентлаг-4
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар-1
- Сургууль-7
- Цэцэрлэг- 5
- Өрхийн эрүүл мэндийн төв-4

"Бага хандгайт" ОНӨААТҮГ нь 2015 онд байгуулагдсан боловч 2020 оноос үйл ажиллагаа явуулаагүй. Манаач нь хуучин захиралтайгаа шүүхдэн үйл ажиллагаа нь зогссон. 2021 онд шинээр А.Ирмүүн захирлаар томилогдсон боловч өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа эхлээгүй тул гэрээ дүгнэх боломжгүй байна.

"Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэхдээ батлагдсан удирдамжийн дагуу 2 багц болгон түрээсийн гэрээтэй байгууллагуудыг 10 үзүүлэлтээр 100 хүртэл оноогоор бусад байгууллагыг 9 үзүүлэлтээр 90 хүртэлх оноогоор дүгнэж, дүгнэлтийг холбогдох зөвлөмжийн хамт тухайн байгууллагын удирдлагуудад таницуулж баталгаажуулсан болно.

"Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэсэн дүнгээр 12 байгууллага "Бүрэн хангалттай", байгууллага "Хангалттай" 7, 2 байгууллага "Ажил сайжруулах шаардлагатай" үнэлгээ авсан.

6. САНХҮҮГИЙН ТАЙЛАН МЭДЭЭ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ТАЛААР:

ТӨБЗГ-аас 2024 оны 02 дугаар сарын 23-нд нийслэлийн өмчит 840 байгууллагуудад тооллогын системээр 2023 оны санхүүгийн тайлангийн нэгтгэл мэдээ оруулах, хүлээн авах тухай сургалт zoom-р зохион байгуулсан сургалтад нягтлангуудыг хамруулах ажлыг зохион байгуулсан.

Сүхбаатар дүүргийн нийт 96 нийслэлийн өмчит төсөвт байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайлангийн нэгтгэл, тодруулгыг шалган тулгалт хийж, "Төрийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын шилжилтийн суурь систем"-ээр нэгтгэв. Мөн хөрөнгийн бүртгэл мэдээллийн болон захиргааны статистикийн ний 17 маягтаар жилийн эцсийн санхүүгийн тайлан мэдээг хүлээн авав.

7. ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Монгол Улсын Засгийн газар, НИТХ, НЗД болон холбогдох дээд байгууллагаас гаргасан тогтоол, захирамж, санамж бичиг, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2021-2024 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулсан.

“Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Налайх дүүргийн “Шинэ-Налайх” цэцэрлэгт хүрээлэнд мод тарих нээлтийн арга хэмжээнд оролцон өөрсдийн зардлаар шинэс модны суулгац авч, хуваарилсан талбайд суулгасан.

-2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан хуваарийн дагуу Баянбүрдийн тойргоос урагшаа Тусгаар тогтнолын талбайн урд үзүүр хүртэлх талбай болон Байгууллагын оффисын дотор ажлын байр, өрөө тасалгаанд тус тус их цэвэрлэгээ хийсэн.


Тайлангийн хугацаанд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 256 албан бичиг хүлээн авснаас 80 албан бичигт хуулийн хугацаанд нь хариуг өгч 1 албан бичиг судлагдаж байна. Хариу өгөлтийн хувь 99,2 % байна. Мөн 1 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд нь хариу өгч шийдвэрлэсэн байна.

8. БУСАД АЖЛЫН ТАЛААР:

- Байгууллагаас зохион байгуулж буй мэдээллийн цагт тогтмол оролцсон.
- НЗДТГ-аас болон байгууллагаас зохион байгуулсан дараах сургалтуудад хамрагдсан байна. Үүнд:
 - -Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалт цахим сургалт;
 - -Нийслэлийн түүх, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, чиг үүрэг;
 - -Өөрчлөлтийн менежмент;
 - -MS Excel /дунд шат, ахисан шат/;
 - -Жендерийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо;
 - Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх;
 - -ТӨБЗГын төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны салбарын нэгдсэн сургалт зөвөлгөө;
 - -2024 оны 7:4:10 цахим сургалтуудад хамрагдсан байна.
 - -ТӨБЗГ-ын 2024.11.28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн Шинэчлэл ба зах зээл хэлэлцүүлэг уулзалт
 - -2024 оны 12 сард компанийн засаглалын хөгжлийн төвийн сургалтад тус тус хамрагдсан.

Тайлан бичсэн:

Өмчийн удирдлага зохицуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн



С.Эрдэмсүвд